



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Агаар, орчны бохиролтой тэмцэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/70/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр Утас: 327734 Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn Аудитор: Ш.Мөнхжаргал Утас: 325093 Цахим хаяг: Munkhjargalsh@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

ЗГ	Засгийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2023.07.20

№ 223

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН АГААР ОРЧНЫ
БОХИРДОЛТОЙ
ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ГАНБОЛД ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 223 дугаар тогтоолоор агаарын чанарыг сайжруулахад зүүн бүсэд Налайх дүүргийг нэмэх шийдвэрийн дагуу 2022 онд Налайх дүүрэгт түүхий нүүрсний хэрэглээг хорих, сайжруулсан шахмал түлшээр хангах ажлыг зохион байгуулагдсан байна..

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд агаарын бохирдлыг бууруулах 5 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 223 дугаар тогтоолоор Агаарын чанарыг сайжруулахад зүүн бүсэд Налайх дүүргийг нэмэх шийдвэр гаргасны дагуу 2022 онд Налайх дүүрэгт түүхий нүүрсний хэрэглээг хорих, сайжруулсан шахмал түлшээр хангах ажлыг зохион байгуулагдсан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх 5 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	837,266,244.69	479,063,424.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	96,950,767.00	27,328,865.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	96,950,767.00	27,328,865.00
3121	Төгрөг	96,950,767.00	27,328,865.00
31211	Төрийн сангийн харилцах	96,950,767.00	27,328,865.00
33	АВЛАГА	114,650,000.00	106,400,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	114,650,000.00	106,400,000.00
34	УРЬДЧИЛГАА	307,524,863.09	47,118,750.00
34600	Урьдчилж гарсан зардал	307,524,863.09	47,078,750.00
3471	Урьдчилгаа тооцоо	00.00	40,000.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	00.00	40,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	318,140,614.60	298,215,809.00
351	Түүхий эд материал	30,902,250.00	68,314,000.00
35110	Тусгай зориулалттай материал	30,902,250.00	68,314,000.00
354	Хангамжийн материал	287,238,364.60	229,901,809.00
35410	Бичиг хэргийн материал	5,699,139.00	6,522,989.00
35420	Аж ахуйн материал	3,085,494.00	824,994.00
35430	Сэлбэг хэрэгсэл	238,016,839.60	196,681,482.00
35440	Түлш, шатах тослох материал	10,370,000.00	9,110,000.00
35470	Бусад хангамжийн материал	30,066,892.00	16,762,344.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,079,717,271.00	4,771,260,136.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,079,717,271.00	4,771,260,136.50
392	Биет хөрөнгө	3,244,332,338.35	2,988,711,956.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,531,627,136.00	2,531,627,136.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-164,598,475.74	-265,863,561.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	260,636,840.00	260,636,840.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-260,636,840.00	-260,636,840.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,742,750,864.00	3,771,862,664.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,250,022,261.64	-3,397,349,418.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,373,200.00	41,943,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,430,932.83	-27,389,835.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	454,903,571.00	454,903,571.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-85,270,762.44	-121,021,800.00
393	Биет бус хөрөнгө	1,835,384,932.65	1,782,548,180.47
39301	Программ хангамж	158,641,200.00	158,641,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-143,691,200.50	-151,891,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	163,259,523.00	163,259,523.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-71,585,789.85	-116,222,542.53
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,916,983,515.69	5,250,323,560.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	281,739,419.45	321,493,203.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	281,739,419.45	321,493,203.00
413	Өглөг	281,739,419.45	321,493,203.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,943,402.45	00.00
4136	Бусад өглөг	279,796,017.00	321,493,203.00
41361	Байгууллагад төлөх өглөг	279,734,059.00	321,493,203.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	61,958.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,635,244,096.24	4,928,830,357.50
51	Засгийн газрын хувь оролцоо	5,635,244,096.24	4,928,830,357.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,653,359,217.41	2,653,359,217.41
51101	Өмч: - төрийн	2,653,359,217.41	2,653,359,217.41

512	Хуримтлагдсан үр дүн	2,981,884,878.83	2,275,471,140.09
51210	Өмнөх үеийн үр дүн	3,082,541,112.46	2,981,884,878.83
51220	Тайлант үеийн үр дүн	-100,656,233.63	-706,413,738.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	5,916,983,515.69	5,250,323,560.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	31,435,066,296.61	29,672,417,497.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,941,083.00	12,524,250.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,941,083.00	12,524,250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,941,083.00	12,524,250.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,906,081.00	12,524,250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,001.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	01.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,420,125,213.61	29,659,893,247.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,236,417,371.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,236,417,371.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,183,707,842.61	29,659,893,247.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,183,707,842.61	29,659,893,247.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,535,722,530.24	30,378,831,235.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,535,722,530.24	30,378,831,235.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,083,330,515.77	30,258,644,787.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	479,470,424.00	495,063,608.94
210101	Үндсэн цалин	334,585,892.00	337,544,372.86
210102	Нэмэгдэл	62,742,605.00	66,597,012.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,173,500.00	56,175,500.00
210104	Урамшуулал	35,968,427.00	34,746,723.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,776,721.64	63,488,559.41
210201	Тэтгэврийн даатгал	45,445,828.16	44,706,418.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,984,139.15	4,882,981.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,825,801.04	3,778,664.10
210204	Ажилгүйдлийн даатгал	956,450.74	920,083.88
210205	Эрүүл мэндийн даатгал	9,564,502.55	9,200,412.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,176,035.04	48,551,222.83
210301	Гэрэл, цахилгаан	12,429,035.04	16,247,514.77
210304	Байрны түрээс	31,747,000.00	32,303,708.06
2104	Хангамж, бараа материалын зардал	18,080,244,809.22	17,668,408,133.00
210401	Бичиг хэрэг	5,825,928.00	4,408,900.00
210402	Тээвэр, шатахуун	18,010,931,742.68	17,554,972,086.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,869,513.54	5,334,479.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	190,380.00	297,598.00
210408	Бараа материал акалсны зардал	58,427,245.00	103,395,068.60
2105	Норматив зардал	3,471,500.00	4,454,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,471,500.00	4,454,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,528,560.00	25,414,083.09
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	15,448,560.00	25,314,083.09
2107	Томилолт, зочны зардал	00.00	848,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	848,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	415,394,938.19	2,449,416,642.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	397,103,617.19	2,426,636,070.52
210803	Даатгалын үйлчилгээ	4,278,675.00	5,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	966,500.00	987,200.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	12,947,146.00	16,694,372.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,980,267,527.68	9,503,000,537.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,695,947,064.35	9,162,861,603.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,841,530.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	282,478,933.33	340,138,934.50
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	452,392,014.47	120,186,448.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,061,958.00	6,474,910.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	3,006,136.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,061,958.00	3,468,774.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	447,330,056.47	113,711,538.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	447,330,056.47	113,711,538.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-100,656,233.63	-706,413,738.74
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН	-100,656,233.63	-706,413,738.74
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	31,435,066,296.61	29,672,417,497.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	31,562,835,395.61	29,787,067,497.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,941,082.00	12,524,250.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,941,082.00	12,524,250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,941,082.00	12,524,250.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,941,082.00	12,524,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,547,894,313.61	29,774,543,247.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,364,186,471.00	114,650,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,364,186,471.00	114,650,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,183,707,842.61	29,659,893,247.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,183,707,842.61	29,659,893,247.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,507,440,295.61	29,755,385,697.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,507,440,295.61	29,755,385,697.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,940,460,239.14	29,520,487,290.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,268,196.00	492,839,170.80
210101	Үндсэн цалин	328,546,205.00	337,828,087.25
210102	Нэмэгдэл	66,784,929.00	66,110,730.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,173,499.00	54,338,226.30
210104	Урамшуулал	36,763,563.00	34,562,127.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,022,947.67	67,656,400.00
210201	Тэтгэврийн даатгал	44,692,054.19	39,652,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,984,139.15	7,434,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,825,801.04	5,302,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	956,450.74	1,387,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,564,502.55	13,878,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,119,721.09	48,551,222.83
210301	Гэрэл, цахилгаан	12,372,721.09	16,247,514.77
210304	Байрны түрээс	31,747,000.00	32,303,708.06
2104	Хангамж, бараа материалын зардал	18,003,595,389.17	17,583,555,047.40
210401	Бичиг хэрэг	7,068,450.00	3,878,400.00
210402	Тээвэр, шатахуун	17,990,648,864.00	17,573,776,620.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,384,676.17	5,334,479.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	493,399.00	565,547.00
2105	Нормативт зардал	5,279,000.00	2,410,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,279,000.00	2,410,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,692,403.09	50,831,784.00

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	570,000.00	00.00
210604	Урсгал засвар	121,122,403.09	50,831,784.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	848,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	848,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	514,614,401.51	2,381,773,557.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	496,323,080.51	2,358,992,985.52
210803	Даатгалын үйлчилгээ	4,278,675.00	5,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	966,500.00	987,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	12,947,146.00	16,694,372.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,708,868,180.61	8,892,022,108.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,706,946,650.61	8,892,022,108.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,921,530.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	566,980,056.47	234,898,406.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	6,536,868.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	3,006,136.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	3,530,732.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	561,980,056.47	228,361,538.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	561,980,056.47	113,711,538.45
213404	Хөрөнгийн		114,650,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	55,195,099.00	31,681,800.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	87,461,600.00	101,303,702.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	87,461,600.00	101,303,702.00
2200	Дотоод эх үүсвэрээр	87,461,600.00	101,303,702.00
223001	Бусад хөрөнгө	32,066,500.00	69,621,902.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	55,395,100.00	31,681,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-87,461,600.00	-101,303,702.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-32,266,501.00	-69,621,902.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	129,017,267.00	96,950,767.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	96,950,767.00	27,328,865.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,632,361,477.41	00.00	3,082,541,112.46	5,714,902,589.87
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,632,361,477.41	00.00	3,082,541,112.46	5,714,902,589.87
Тайлант үеийн үр дүн	20,997,740.00	00.00	-100,656,233.63	-79,658,493.63
2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,653,359,217.41	00.00	2,981,884,878.83	5,635,244,096.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,653,359,217.41	00.00	2,981,884,878.83	5,635,244,096.24
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,653,359,217.41	00.00	2,981,884,878.83	5,635,244,096.24
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-706,413,738.74	-706,413,738.74
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,653,359,217.41	00.00	2,275,471,140.09	4,928,830,357.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,339,265,400.00	29,558,705,958.55	4,780,559,441.45	86%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,339,265,400.00	29,558,705,958.55	4,780,559,441.45	86%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,331,259,200.00	29,552,169,090.55	4,779,090,109.45	86%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,660,100.00	492,839,170.80	2,820,929.20	99%
210101	Үндсэн цалин	340,682,000.00	337,828,087.25	2,853,912.75	99%
210102	Нэмэгдэл	63,000,000.00	66,110,730.00	(3,110,730.00)	105%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,310,000.00	54,338,226.30	(8,028,226.30)	117%
210104	Урамшуулал	45,668,100.00	34,562,127.25	11,105,972.75	76%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,656,400.00	67,656,400.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	39,652,800.00	39,652,800.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	7,434,900.00	7,434,900.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,302,400.00	5,302,400.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,387,900.00	1,387,900.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	13,878,400.00	13,878,400.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,784,500.00	48,551,222.83	16,233,277.17	75%
210301	Гэрэл, цахилгаан	31,155,700.00	16,247,514.77	14,908,185.23	52%
210304	Байрны түрээс	33,628,800.00	32,303,708.06	1,325,091.94	96%
2104	Хангамж, бараа материалын зардал	20,228,145,700.00	17,583,555,047.40	2,644,590,652.60	87%
210401	Бичиг хэрэг	3,268,300.00	3,878,400.00	(610,100.00)	119%
210402	Тээвэр, шатахуун	20,218,531,600.00	17,573,776,620.50	2,644,754,979.50	87%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,845,800.00	5,334,479.90	511,320.10	91%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	565,547.00	(65,547.00)	113%

**Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2105	Норматив зардал	3,750,000.00	2,410,000.00	1,340,000.00	64%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,000.00	2,410,000.00	1,340,000.00	64%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	95,024,000.00	61,519,784.00	33,504,216.00	65%
210604	Урсгал засвар	95,024,000.00	61,519,784.00	33,504,216.00	65%
2107	Томилолт, зочны зардал	2,345,400.00	848,000.00	1,497,400.00	36%
210702	Дотоод албан томилолт	2,345,400.00	848,000.00	1,497,400.00	36%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,725,675,000.00	2,402,767,357.52	322,907,642.48	88%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,700,000,000.00	2,379,986,785.52	320,013,214.48	88%
210803	Даатгалын үйлчилгээ	6,540,000.00	5,000,000.00	1,540,000.00	76%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,380,000.00	987,200.00	392,800.00	72%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	500,000.00	99,000.00	401,000.00	20%
210807	Газрын төлбөр	17,255,000.00	16,694,372.00	560,628.00	97%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,648,218,100.00	8,892,022,108.00	1,756,195,992.00	84%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,648,218,100.00	8,892,022,108.00	1,756,195,992.00	84%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,006,200.00	6,536,868.00	1,469,332.00	82%
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,006,200.00	6,536,868.00	1,469,332.00	82%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,006,200.00	3,006,136.00	64.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	3,530,732.00	1,469,268.00	71%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,339,265,400.00	29,558,705,958.55	4,780,559,441.45	86%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,324,265,400.00	29,546,181,708.55	4,778,083,691.45	86%
132001	Орон нутгийн төсвөөс	34,324,265,400.00	29,546,181,708.55	4,778,083,691.45	86%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	12,524,250.00	2,475,750.00	83%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	12,524,250.00	2,475,750.00	83%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	38.00	38.00	-	100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	-	100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	40.00	40.00	-	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		114,650,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		114,650,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		114,650,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		114,650,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		114,650,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		114,650,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		114,650,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын үйл ажиллагааны чиглэлийг Нийслэлийн Засаг даргын 2022 он 02 дугаар сарын 11-ний өдрийн А/164 тоот захирамжаар агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, агаар, орчны бохирдлын хэмжилт хийх, судалгаа гаргах, олон нийтийн оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн түлшний үйлдвэрлэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжих, иргэн, аж ахуйг нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу орчны агаарын чанар болон агаар бохирдуулах эх үүсвэрийн хаягдал хийг тодорхойлох хэмжилтийн ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах, агаарын чанарыг тодорхойлох, агаарын бохирдолд хяналт, шинжилгээ судалгаа хийх, бохирдуулагч эх үүсвэрүүдээс байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, төр засаг болон иргэд олон нийтийг үнэн зөв мэдээ, мэдээллээр хангах явдал хэмээн тодорхойлжээ.

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь эрхэм зорилгоо “Агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх болон байгаль орчин, үйлдвэр, технологийн хүрээнд хяналт тавих замаар иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд оршино” хэмээн тодорхойлж, тайлант онд 5 зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

3.2 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдсан
- ЗГ-ын 2022 оны 192 дугаар тогтоолоор цалингийн шатлал шинэчлэн тогтоосон
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын 2022 оны 12 дүгээр сарын 21-ний өдрийн А/109 дүгээр тушаалаар бэлтгэн гаргасан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4.3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны санхүүгийн тайлант Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг байгууллагын онцлогт нийцүүлэн урсгал засварын сайжруулалтыг тодотгон, газрыг үнэлж, бүртгэх талаар өөрчлөлтийг нэмж оруулсан.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 666,660.0 мянган төгрөгөөр буюу 11.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	96,950.8	27,328.9	-69,621.9
Авлага	114,650.0	106,400.0	-8,250.0
Урьдчилж гарсан зардал	307,524.8	47,118.7	-260,406.1
Бараа материал	318,140.6	298,215.8	-19,924.8
Үндсэн хөрөнгө	5,079,717.3	4,771,260.2	-308,457.1
Нийт хөрөнгө	5,916,983.5	5,250,323.5	-666,660.0
Өр төлбөр	281,739.4	321,493.2	39,753.8
Засгийн газрын оролцоо	5,635,244.1	4,928,830.3	-706,413.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,916,983.5	5,250,323.6	-666,660.0

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө 27,328.9 мянган төгрөг болж 69,621.1 мянган төгрөгөөр буурсан нь 29,787,067.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 29,755,385.7 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 101,303.7 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 106,400.0 мянган төгрөг болж 8,250.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулахаар төрийн сангаас санхүүжилт олгосон боловч тайлант онд хил нээгдээгүйн улмаас авлагыг барагдуулах боломжгүй тул орон нутгийн төсөвт зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 47,118.7 мянган төгрөг болж 260,406.1 мянган төгрөгөөр буурсан нь сайжруулсан шахмал түлшний борлуулалтын урамшуулал, тээврийн компаниудад тээврийн зардал, агаарын нүүрстөрөгчийн хийн хэмжилтийн багаж засварлахаар шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 298,215.8 мянган төгрөг болж 19,924.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 191,936.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, нийт 211,860.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,771,260.2 мянган төгрөг болж 308,457.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 29,111.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,570.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл төсвийн хөрөнгөөр худалдан авч 340,138.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,928,830.3 мянган төгрөг болж 706,413.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 35,095,116.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, орон нутгийн төсвөөс 35,085,116.2 мянга, үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 34,339,265.4 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 34,324,265.4 мянган төгрөг үйл ажиллагааны орлогоос 15,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 29,659,893.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 12,524.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 29,558,705.9 мянган төгрөгийг зарцуулж, 113,711.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 29,558,705.9 мянган төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2,820.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 16,233.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 2,644,590.7 мянга, норматив зардал 1,340.0 мянга, эд хогшил худалдан авах 33,504.2 мянга, томилолт, зочны зардал 1,497.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 322,907.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,756,196.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 1,469.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71407- Агаар, орчны бохирдолтой тэмцэх	34,339,265.4	29,558,705.9	4,780,559.4	86.1
1.1	80801-Үндсэн үйл ажиллагааны зардал	781,135.3	722,167.4	58,967.9	92.4
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	8,006.2	6,537.0	1,469.2	81.6
1.3	81707-Агаарын бохирдлыг бууруулах	33,550,123.9	28,830,001.7	4,720,122.2	85.9
	Дүн	34,339,265.4	29,558,705.9	4,780,559.4	86.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нийслэлийн ЗДТГ-аас 114,650.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсөвт зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах видео шторк, контентыг бүртгэлд авах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулж, гүйцэтгэсэн ажлын үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж байх, бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг и баримтаар баталгаажуулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн хэлтсийн аудитор Ш.Мөнхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 25,172,041.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 503,440.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын 2022 онд зарласан Орчны агаарын чанарын суурин харуулын тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл худалдан авах тендерийн сонгон шалгаруулалт хүчингүй болж 58,967.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,469.3 мянган төгрөг, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд бий болсон 4,720,122.2 мянган төгрөг, нийт 4,780,559.4 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллээс 7 дугаар сард 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1 “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ*” заалттай тус тус нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа, зөрчил илрүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 85,533.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 52,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 150,653.0 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлэн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 1/280 дугаар бүхий албан бичгээр хариуг ирүүлсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	85,533.8	2	85,533.8	100.0
Албан шаардлага	1	52,000.0	1	52,000.0	100.0
Зөвлөмж	5	150,653.0	5	150,653.0	100.0
Нийт дүн	8	288,186.8	8	288,186.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 322,977.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 5,168.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 327,810.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 48,636.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Төсвийн хөрөнгөөр 2,568.7 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" заалтуудтай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

2. Төсвийн хөрөнгөөр ажиллагсдын 2,600.0 мянган төгрөгийн хувцас авч нөөцөлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно." заалтыг зөрчсөн, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

5.2 Албан шаардлага

1. Ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулаагүйгээс 250,980.3 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1. "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч нь дараах эрх, үүрэгтэй байна" 19.1.4 "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" заалтыг зөрчсөн, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

2. Ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулаагүй, төсвийг зөв зохистой удирдаагүйгээс 47,118.7 мянган төгрөгийн авлага үүссэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1. "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч нь дараах эрх, үүрэгтэй байна: 19.1.4 "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" заалтыг зөрчсөн, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

3. Шаардлагагүйгээр их хэмжээгээр 29,711.8 мянган төгрөгийн бараа, материал бэлтгэж, нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" заалтыг зөрчсөн, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Тайлант хугацаанд цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг 37,399.9 мянган төгрөгийн зөрүүтэй шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтыг зөрчсөн, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

Илрүүлэлт-2: Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд 11,236.7 мянган төгрөгийг тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг зөрчсөн, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэсэн ажлын үр дүнг үнэлж, гэрээ дүгнэж байх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-3: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй 196 нэр төрлийн 3,518,783.2 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалтыг хэрэгжүүлээгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.	1	2,568.7	1	2,568.7								
Ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулаагүйгээс авлага үүссэнийг баталгаажуулаагүй.	1	47,118.7			1	47,118.7						
Ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулаагүйгээс өр төлбөр үүссэнийг, тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	250,980.3			1	250,980.3						
Төсвийн хөрөнгөөр ажиллагсдын хувцас авч нөөцөлсөн.	1	2,600.0	1	2,600.0								
Шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх, нөөцөлсөн бараа материалаа бөөнөөр орлого авсан.	1	29,771.8			1	29,771.8						
Элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй 196 нэр төрлийн 3,518,783.2 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлээгүй.	1	-					1	-				
Тайлант хугацаанд цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн.	1	37,399.9					1	37,399.9				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан.	1	11,236.7					1	11,236.7				
Дүн	9	381,676.1	2	5,168.7	3	327,870.8	3	48,636.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд төсвийн төсөл, хандив тусламжийн орлогын мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроож 110 мэдээлэл байршуулсан.	1	530,950.3					1	530,950.3
Дүн	1	530,950.3					1	530,950.3